

НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРОО

ТАЙЛАН

2024 оны 11 дүгээр сарын 18

Улаанбаатар хот

Хүний нөөцийн мэдээлэл

Төрийн албаны тухай хуулиар төрийн албаны ангилал, зарчим, төрийн албан тушаал түүнд тавигдах шаардлага, төрийн албан хаагчийн эрх зүйн байдал, төрийн алба хаах болзол, журмыг зааж төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл баталгааг зохицуулсан байдаг. Монгол улсын Үндсэн хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгааг хуулиар тогтооно”, 2002 онд батлагдсан Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3-т “Төрийн байгууллагаас төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу байгууллага “Хүний хөгжлийн хөтөлбөр 2022-2025”-г боловсруулан баталж, хэрэгжүүлж эхлээд байна.

Мөн Байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмыг Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар шинэчлэн, хамтран боловсруулж, удирдлагаар батлуулав. Мөн Хөдөлмөрийн гэрээг шинэчлэн батлуулж, байгуулав.

2022 онд батлагдсан шинэ бүтцийн өөрчлөлтийн хүрээнд Дарга, Нягтлан бодогч, Спортын хэлтсийн дарга, Биеийн тамирын хэлтсийн дарга, Тогтоол шийдвэрийн биелэлт, хяналт, шинжилгээ, үнэлгээний асуудал хариуцсан Ахлах мэргэжилтэн, Өсвөрийн шигшээ баг, хүүхдийн спортын асуудал хариуцсан мэргэжилтэн, Спортын тэмцээн, наадам, спортын холбоодын асуудал хариуцсан мэргэжилтэн, Спортын сургалт-дасгалжуулалтын бодлогын хэрэгжилтийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Хүний нөөц, бичиг хэрэг, архивын асуудал хариуцсан мэргэжилтэн, Ахмад, хөгжлийн бэрхшээлтэй хүний биеийн тамирын асуудал хариуцсан мэргэжилтэн, Биеийн тамирын Бодлогын хэрэгжилтийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Биеийн тамирын арга зүйчийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Үйлчлэгч гэсэн 13 ажилтан, албан хаагчийн бүрэлдэхүүнтэй, Нярав, Биеийн тамир спортын статистик, цахим мэдээллийн сангийн асуудал хариуцсан мэргэжилтэн зэрэг ажил үүргийг хавсран гүйцэтгэж үйл ажиллагаагаа явуулж байна.


Байгууллагад бүтцийн өөрчлөлт явагдсантай холбоотой ажилтан, албан хаагчдын төрийн албаны ангилал, зэрэглэл, цалин урамшууллын өөрчлөлтийг тухай бүрт нь <https://hr.csc.gov.mn> , <https://erp.ulaanbaatar.mn> сайтын хүний нөөцийн мэдээлэлд шинэчлэн дор бүрт нь шивж оруулан ажиллаж байна.

2024 онд батлагдсан 84, 128 дугаар тогтоолуудыг үндэслэн цалингийн доод хэмжээ нэмэгдсэнтэй холбогдуулан 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн цалинг шинэчлэн тогтоолгож, олгож эхлэв.

2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн ажилчдын санаачлагаар байгууллагын дотоод журамд өөрчлөлт орж хоол, унааны хөнгөлөлтөд өөрчлөлт орлоо.

1.Жендерийн харьцаа


Байгууллагын эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа, ажил эрхлэлтийн харилцаанд мэдээллийг дор оруулав. (Зураг 1)



Зураг 1. Жендерийн харьцаа


2.Насны ангилал

Ажилтан, албан хаагчдыг насны ангиллаар авч үзвэл 25-30 насны 3 (23.07%), 31-35 насны 3 (23.07%), 35-40 насны 3 (23.07%), 45-55 насны 4 (30.76%) албан хаагчидтай нийт 13 ажилтантайгаар ажиллаж байна. (Зураг 2)




3.Мэргэжлийн ангилал

Ажилтан, албан хаагчдыг мэргэжлийн ангиллаар авч үзвэл Биеийн тамир, спортын багш, дасгалжуулагч 9 (61.53%), Спорт аялал жуулчлалын менежер 1 (7.69%), Нягтлан бодогч, нярав 2 (15.38%), Хүний нөөц, бичиг хэрэг 1 (7.69%) мэргэжилтэй нийт 13 ажилтантайгаар ажиллаж байна. (Зураг 3)



4.Зэргийн ангилал

Ажилтан, албан хаагчдын Спортын мастер зэрэгтэй 7 (53.8%), Зэрэггүй 6 (46.1%) албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаалд ажиллаж байна. (Зураг 4)



Зураг 4. Цол зэргийн ангилал

5.Ээлжийн амралт

Ажилтан, албан хаагчдын ээлжийн амралтыг дараах хуваарийн дагуу олгоно. Үүнд:

03 сард: Э.Ууганчимэг

07 сард: Д.Отгонсүрэн, Ю.Батсайхан, С.Сувд, Г.Ууганжаргал, Э.Уянга, Б.Мөнхзаяа, О.Түмэнжаргал, А.Аззаяа, И.Бат-Эрдэнэ, Ж.Бадамцэцэг

08 сард: Г.Билгүүн, П.Бат-Оюун, Н.Сэмжид нарыг тус тус амарлаа.

6.Сахилгын шийтгэл ногдуулсан ажилтан, албан хаагчдын мэдээлэл

“Хөдөлмөрийн дотоод журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.1.9.1 дэх заалтыг зөрчсөн тул Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.3 дахь заалтыг үндэслэн 2022 оны 10 дугаар сард 3 сарын хугацаанд Үндсэн цалингийн 20 хувиар тооцож Нягтлан бодогч П.Бат-Оюунд шийтгэвэр ногдуулсан. 2023 оны 09 дүгээр сард 2 дугаар улирлын тайлан хоцроож тушаасан тул 1 сарын хугацаанд Үндсэн цалингийн 10 хувиар тооцож Нягтлан бодогч П.Бат-Оюунд шийтгэвэр ногдуулсан. Үүнээс хойш 2024 оны 05 дугаар сарын 13-ны байдлаар сануулгатай 1 мэргэжилтэнтэй, сахилгын шийтгэл ногдуулсан ажилтан байхгүй ажиллаж байна.

7.Нээлттэй ажлын байр

2024 он гарснаар Нээлттэй ажлын байр Нярвын орон тооны 1, Биеийн тамирын бодлогын хэрэгжилтийн асуудал хариуцсан мэргэжилтэн орон тооны 1-г 2024 оны 10 дугаар сарын 01-нд нөхөж, Биеийн тамир спортын статистик, цахим мэдээллийн сангийн асуудал хариуцсан мэргэжилтэн жирэмсний амралтаа авсны улмаар түр ажлын байрны 1 орон тоо нийт 2 ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарласан боловч ажил горилогч өнөөдрийн байдлаар ирээгүй тул сонгон шалгаруулалт зарласан хэвээр байна.

8.Сургалт

Улсын Их Хурлын 2004 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратегийн баримт бичиг”-ийн 4.3-т “Байгууллагын болон хүний нөөцийн хөгжлийн стратеги”-ийн “Шинэтгэлийн дунд хугацаанд сонгон шалгаруулах үйл ажиллагааг ирээдүйд шаардагдах ажилтны орон тоо, ур чадвар, мэдлэг чадвар ба зардлыг тусгасан байгууллагын хүний нөөцийн төлөвлөгөөтэй нягт уялдуулан хэрэгжүүлэх болно.

Хүний нөөцийн төлөвлөлт нь байгууллагын стратеги төлөвлөгөөнд тусгасан зорилт болон стратегид үндэслэсэн байх болно.

Байгууллагын бүтэц болон хөгжлийн стратеги нь хүний нөөцийн төлөвлөлтийн нэг хэсэг байх болно”, “Хүний нөөцийн удирдлагын загварын хүрээнд яам, агентлагийн хүний нөөцийн удирдлагын ур чадварыг бэхжүүлэх, төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалтны үндсэн мэдлэг чадварыг хөгжүүлэх, албан тушаалд сонгон томилох үйл явцыг боловсронгуй болгох шаардлагатай” гэж тус тус заасан нь хүний

нөөцийн бодлогын хөтөлбөрийн үндэс болдог бөгөөд сургалтын хөтөлбөрийн эрх зүйн үндэс болж байна.

Холбогдох байгууллагуудаас 2024 оны 01 дүгээр сарын 02-ноос 11 дүгээр сарын 18-ныг хүртэлх хугацаанд зохион байгуулагдсан 30 удаагийн цахим болон танхимын сургалт, уулзалт, арга хэмжээнд 13 албан хаагчдыг идэвхтэй хамруулсан байна.

Байгууллагын ажилтан, албан хаагчдаас Биеийн тамирын хэлтсийн дарга С.Сувд Удирдлагын академийн Төрийн удирдлагын магистрийн түвшинд, Тогтоол шийдвэр, хяналт шинжилгээ үнэлгээний ахлах мэргэжилтэн Б.Мөнхзаяа Монгол улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн Эрх зүйчийн бакалаврын түвшинд, Хүний нөөц, бичиг хэрэг, архивын асуудал хариуцсан мэргэжилтэн А.Аззаяа Отгонтэнгэр сургуулийн Эдийн засаг, Бизнес удирдлагын сургуулийн Хүний нөөцийн менежментийн магистрын түвшинд, Спортын сургалт-дасгалжуулалтын бодлогын хэрэгжилтийн асуудал хариуцсан мэргэжилтэн Э.Уянга Монгол улсын боловсролын их сургуулийн Биеийн тамирын сургуулийн Спортын онол арга зүйн тэнхимийн Биеийн тамирын боловсролын удирдлагын магистрийн түвшинд тус тус суралцаж байна.

№	Сургалт, арга хэмжээ	Хэзээ	Хамрагдсан албан хаагчдын тоо
1	2	3	4
1.	“Хяналт-шинжилгээ үнэлгээ”-ний сургалт	2024.01.15	Б.Мөнхзаяа Э.Ууганчимэг
2.	Төрийн архив, албан хэрэг хөтөлөлтийн стандартын сургалт	2024.01.31	14
3.	Биеийн тамир спортын байгууллагын удирдах ажилтны уулзалт, зөвлөгөөн	2024.01.12	Д.Отгонсүрэн С.Сувд
4.	Иогийн багш бэлтгэх сургалт	2024.01.15	Ж.Бадамцэцэг
5.	Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль болон тэдгээрт нийцүүлэн гаргасан Засгийн газрын тогтоол, дүрэм, журмыг сурталчлан таниулах” сургалт	2024.03.01	14
6.	Биеийн тамир спортын салбарын 100 жилийн ойн баннер бэлтгэх “Дизайн” сургалт	2024.03.01	Э.Ууганчимэг
7.	Азийн хөл бөмбөгийн холбооны эмэгтэйчүүдийн Хөл бөмбөгийн өдөрлөг	2024.03.06	3
8.	“Монита-2024” мартын 8, Монгол цэргийн өдрүүдийг хамтатган тэмдэглэсэн арга хэмжээ	2024.03.11	14
9.	Гэр бүл хүүхэд хамгаалалын нээлттэй өдөрлөг, хууль зүйн зөвлөгөө, хүүхэд хамгааллын 108 утасны талаарх мэдээлэл	2024.03.16	А.Аззаяа
10.	Баянзүрх дүүргийн Засаг даргын нэрэмжит Спортын 7 төрөлт тэмцээн, арга хэмжээ	2024.03.13-17	14
11.	Эрчүүдийн чуулган	2024.03.17	3
12.	“Archive E-doc системд цаасан суурьт баримт хадгалах арга зүй” сэдэвт сургалт	2024.03.18-20	А.Аззаяа
13.	Төрийн албаны зөвлөлөөс 7:4:10 сургалт:Байгууллага хувь хүний санхүү төлөвлөлт, удирдлага	2024.03.21	А.Аззаяа
14.	Төрийн албаны зөвлөлөөс 7:4:10 сургалт:Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэгийг тодорхойлох судалгаа, Төрөөс Монгол хэлний талаар баримталж буй бодлого	2024.03.28	А.Аззаяа
15.	Ази тивийн аварга шалгаруулах, олимпын эрх авах тэмцээний үеэр зохион байгуулагдсан Дэлхийн бөхийн холбооны Киргиз улсын Бишкек хотод болсон шүүгч бэлтгэх, зэрэг ахиулах сургалт	2024.04.07	Ю.Батсайхан
16.	Биеийн тамир, спортын хороодын Албан хаагчдын мэргэжил дээшлүүлэх богино хугацааны сургалт БНХАУ-ын Бээжин хотын Спортын их сургууль	2024.04.18-24	О.Түмэнжаргал

1	2	3	4
17.	Хаврын их цэвэрлэгээ	2024.04.08	14
18.	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн хэлтсээс зохион байгуулдаг төлөвлөгөөт сургалтууд болох "Хууль эрх зүй- Төрийн албан хаагчийн хариуцах ажил, үйлчилгээ, Асуудал шийдвэрлэх арга зам сургалт"	2024.05.10	Н.Сэмжид
19.	CANVA программын сургалт (Брошур, өргөмжлөл, лого, reel)	2024.04.04-05	14
20.	Орчин цагийн Биеийн тамир, спортын салбар үүсэж хөгжсний ойн арга хэмжээнд зориулсан Мод тарих өдөрлөг	2024.05.11	10
21.	Орчин цагт Биеийн тамир, спортын салбар үүсэж хөгжсний 100 жилийн ойн зөвлөгөөн	2024.05.24	7
22.	Орчин цагт Биеийн тамир, спортын салбар үүсэж хөгжсний 100 жилийн ойн арга хэмжээний хүрээнд ОУ-н эрдэм шинжилгээний хурал	2024.05.27	3
23.	Орчин цагт Биеийн тамир, спортын салбар үүсэж хөгжсний 100 жилийн ойн арга хэмжээний хүрээнд Нийслэлийн бүсийн спортын 5 төрөлт арга хэмжээ	2024.05.28-29	14
24.	Бидний гэр бүл, хүүхэд өдөрлөг	2024.05.29	14
25.	Zangia academy Ажлын байрны чадвар, хувь хүний хөгжлийн сургалтууд: Архивын бүртгэл зохион байгуулалт хийх, Монгол хэлний найруулга зүй, Ажилтны хөдөлмөрийн эрх зүй, Ажилтны ёс зүй ба хариуцлага, Ажилтны ажлын байран дээрх анхны тусламж	2024.05.20-06.07	А.Аззаяа
26.	Нийслэлийн Хүний нөөцийн газраас: Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах биелэлтийг тайлагнах, үнэлэх талаар шинээр батлагдсан хууль тогтоомжийн зохицуулалт сэдэвт сургалт	2024.06.11	6
27.	Архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтны мэргэжил олгох сургалт	2024.09.02-30	А.Аззаяа
28.	Спортын анагаах ухаан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нөхөн сэргээх нийгэмлэгтэй хамтран эмч мэргэжилтнүүд, дасгалжуулагч, тамирчдад зориулсан сургалт	2024.09.09	Э.Уянга, Н.Сэмжид
29.	Төрийн албаны цалингийн нэгдсэн систем "Тэтгэмж" цэсийг ашиглах сургалт	2024.09.05	П.Бат-Оюун
30.	Намрын их цэвэрлэгээ	2024.09.06	14
31.	Албан бичиг солилцооны дундын систем "DOCX" сургалт	2024.09.10	А.Аззаяа
32.	Жендэрийн цахим сургалт	2024.10.03	13
33.	Орчин цагт Биеийн тамир, спортын салбар үүсэж хөгжсний 100 жилийн ой, Сонгинохайрхан дүүргийн Биеийн тамир, спортын хороо үүсэж байгуулагдсны 30 жилийн ойн арга хэмжээний хүрээнд Нийслэл, дүүргийн ажилтан албан хаагчдын дунд спортын 4 төрөлт арга хэмжээ	2024.10.17	13
34.	Намрын их цэвэрлэгээ	2024.10.25	13
35.	Жендэрийн сургалт БЗД-н ЗДТГазарт	2024.10.31	А.Аззаяа
36.	Биеийн тамир, спортын Бүтээлч сарын аяны нээлтийн арга хэмжээ	2024.11.02	13
37.	Төрийн албаны зөвлөлөөс 7:4:10 сургалт:"Төрийн албан хаагчийн ёс зүй ба эрүүл мэнд" М.Цэрэнбат (Ph.D), Ёс зүйн хорооны гишүүн	2024.11.07	9
38.	"Хүүхдийн спорт- Бие бялдрын хүмүүжил- Олимпын боловсрол" сэдэвт сургалт зөвлөгөөн	2024.11.07	Д.Отгонсүрэн С.Сувд
39.	Төрийн албаны цалингийн нэгдсэн систем сургалт	2024.11.07	П.Бат-Оюун
40.	БЗД-н ЗДТГ-ын Эрх бүхий албан тушаалтнуудтай хийх уулзалт	2024.11.07	А.Аззаяа
41.	Төрийн албаны зөвлөлөөс 7:4:10 сургалт:"Төрийн албан хаагчийн ёс зүйн гомдол мэдээлэл, зөрчлийг шийдвэрлэх үе шат" Д.Баатарсайхан Ёс зүйн хорооны гишүүн, Төрийн албаны зөвлөлийн гишүүн.	2024.11.14	13

БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТАН, АЛБАН ХААГЧДЫН 2024 ОНЫ ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН

№	Нэр	Албан тушаал	Ажилд орсон	Ажлаас чөлөөлөгдсөн	Тайлбар
1	Ж.Бадамцэцэг	Үйлчлэгч	2024.01.02 Б/02		Ажилд авав
2	Г.Ууганжаргал	Мэргэжилтэн	2024.08.30 Б/15	Ажлаас чөлөөлөх, шилжүүлэн ажиллуулах	
3	Э.Уянга	Мэргэжилтэн	2024.09.04 Б/16		Нэгж хооронд өөрийн хүсэлтээр шилжүүлэн ажиллах
4	Э.Ууганчимэг	Мэргэжилтэн	2024.10.03 Б/19		Жирэмсний амралт авсан.
5	Э.Тулга	Мэргэжилтэн	2024.10.01 Б/20		Ажилд авав
6	Б.Мөнхзаяа	Ахлах мэргэжилтэн	2024.10.03 Б/21		Ажил үүрэг хавсран гүйцэтгүүлэх

ТАНИЛЦСАН

Д.ОТГОНСҮРЭН
(ДАРГА)

ХЯНАСАН

Б.МӨНХЗАЯА
(ТОГТООЛ ШИЙДВЭР, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ
ҮНЭЛГЭЭНИЙ АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН)

БОЛОВСРУУЛСАН

А.АЗЗАЯА
(ХҮНИЙ НӨӨЦ, БИЧИГ ХЭРЭГ, АРХИВЫН
АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН)